



И-МОНГОЛ АКАДЕМИ УТУГ-ЫН ЗАХИРАЛ
Б.МЯГМАРНАРАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023. 02. 17 № 07/259
таний -ны № -т

Г Хязгаарлалттай дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу И-Монгол академи УТУГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайландаа үзүүлэх нөлөөг эс тооцвол И-Монгол академи УТУГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

И-Монгол академи УТУГ нь Засгийн газрын 2021 оны 283 дугаар тогтооолоор үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад зайлшгүй шаардлагатай хөрөнгийг урсгал төсвөөс бэлтгэхдээ нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь багцалж тендер шалгаруулалт явуулаагүй, мөн нэр бүхий 1 аж ахуйн нэгжтэй "Ажил гүйцэтгүүлэх гэрээ"-г байгуулан засварын ажлын зураг төслийг хийлгэсэн боловч засварын ажил хийгдээгүй, үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

И-Монгол академи УТҮГ нь 2022 онд төрийн үйлчилгээний нэгдсэн e-mongolia.mn, үйлчилгээний байгууллагуудад зориулсан lavlagaa.e-mongolia.mn, төрийн байгууллагуудаас аж ахуйн нэгжид үзүүлж байгаа үйлчилгээг нэгтгэсэн e-business.mn вэб сайтууд болон ЗГХЭГ-ын хурлын e-cabinet зэрэг томоохон системийг шинээр хөгжүүлэн ашиглалтад оруулсан байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн e-mongolia.mn системд 71 төрийн байгууллагын 806 үйлчилгээг нэгтгэж, төрийн мэдээлэл солилцооны дундын ХҮР, танилт нэвтрэлтийн ДАН, албан бичиг солилцох дундын DOCx, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системүүдийн хөгжүүлэлт, хэвийн найдвартай ажиллагааг ханган шинэчлэлт, сайжруулалтыг хийсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын захирлын тушаалаар баталсан "Албан тушаалын цалингийн шатлал, сүлжээ"-г мөрдөж байгаа нь холбогдох хууль, тогтоомжид заасантай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

И-Монгол академи УТҮГ-ын захирлын 2022 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хурэх үр дүнгийн талаарх чанаарын болон тоон хэмжээний үзүүлэлтэд тусгасан 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн 64 арга хэмжээг нийт 97.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн ба 3 арга хэмжээний гүйцэтгэл зорилтот түвшинд хүрээгүй байна. Тухайлбал:

1. Төрийн бүх салбарын серверийн талаар судалгаа хийх;
2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан ёсны вэб хуудсыг монгол бичгийн хувилбараар хөгжүүлэх;
3. Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ур чадварын бүтцийн хүрээг тодорхойлж, сургалтын хөтөлбөр боловсруулах;

Санхүүгийн тайландаа төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага


Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ анgid эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

